

ШИЛДЭГ БҮТЭЭЛ ШАЛГАРУУЛАХ УДИРДАМЖ

НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

1.1. Шилдэг бүтээлийг шагналд нэр дэвшүүлэх болон урамшуулах үйл ажиллагаатай холбогдсон харилцааг энэхүү удирдамжаар зохицуулна.

ХОЁР. ЗОРИЛГО

2.1. Соёлын бүтээлч үйлдвэрлэл эрхлэгчдийн бүтээн туурвих үйл ажиллагаа, бүтээлч санал санаачлагыг дэмжих, шилдэг бүтээлийг тодруулан алдаршуулах зорилгоор зохион байгуулагдана.

ГУРАВ. ШАЛГАРУУЛАХ БҮТЭЭЛИЙН ТӨРӨЛ

3.1. “Монгол улсын иргэн, хуулийн этгээдийн бүтээлч үйл ажиллагааны үр дүнд бий болсон, нийгмийн эрэлт хэрэгцээнд нийцсэн, үндэсний өв уламжлал, ёс заншил, соёлын онцлогийг агуулсан, зохиогчийн эрхийн зөрчилгүй, дэвшилтэт технологи, инновацад суурилсан, импортыг орлох, экспортод чиглэсэн, өрсөлдөх чадвартай соёлын агуулга, урлагийн бүтээлээс дор дурьдсан 12 чиглэлийн хүрээнд шилдэгийг тодруулна.

3.1.1. Шилдэг виртуаль үзмэр (Өв соёл)

Соёлын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.2-д заасан үйл ажиллагаа эрхэлдэг иргэн, хуулийн этгээдийн бүтээлч үйл ажиллагааны үр дүнд бий болсон, нийгмийн эрэлт хэрэгцээнд нийцсэн, үндэсний өв уламжлал, ёс заншил, соёлын онцлогийг агуулсан, дэвшилтэт технологи, инновацад суурилсан, олон улсын түвшинд өрсөлдөх чадвартай, соёлын өвийг орчин үеийн технологийг шийдлийг ашиглан танилцуулах боломжийг бүрдүүлсэн виртуаль үзмэрт (*AR, VR үзмэр гм*) олгох шагнал

3.1.1. Ном хэвлэлийн шилдэг бүтээл (Утга зохиол, ном хэвлэл)

Соёлын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.4-д заасан үйл ажиллагаа эрхэлдэг иргэн, хуулийн этгээдийн бүтээлч үйл ажиллагааны үр дүнд бий болсон, нийгмийн эрэлт хэрэгцээнд нийцсэн, үндэсний өв уламжлал, ёс заншил, соёлын онцлогийг агуулсан, хэвлэлийн бүтээгдэхүүнд тавигдах олон улсын стандартыг хангасан, уран зохиол, шинжлэх ухаан, танин мэдэхүй, түүхийн онцгой ач холбогдолтой ном хэвлэлийн бүтээлд олгох шагнал

3.1.2. Дуу хөгжмийн шилдэг бүтээл (Дуу хөгжим)

Соёлын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.5-д заасан үйл ажиллагаа эрхэлдэг иргэн, хуулийн этгээдийн бүтээлч үйл ажиллагааны үр дүнд бий болсон, нийгмийн эрэлт хэрэгцээнд нийцсэн, үндэсний өв уламжлал, ёс заншил, соёлын онцлогийг агуулсан, дэвшилтэт технологи, инновацад суурилсан, импортыг орлох, экспортод чиглэсэн, өрсөлдөх чадвартай дуу хөгжмийн үйлдвэрлэлийн бүтээгдэхүүнд (*цомог, пянз гэх мэт*) олгох шагнал

3.1.3. Тайзны урлагийн шилдэг бүтээл (Тайзны урлаг)

Соёлын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.6-д заасан үйл ажиллагаа эрхэлдэг иргэн, хуулийн этгээдийн бүтээлч үйл ажиллагааны үр дүнд бий болсон, нийгмийн эрэлт хэрэгцээнд нийцсэн, үндэсний өв уламжлал, ёс заншил, соёлын онцлогийг агуулсан, дэвшилтэт технологи, инновацад суурилсан, өрсөлдөх чадвартай тайзны урлагийн бүтээлд (*концерт, жүжиг, цирк гэх мэт*) олгох шагнал

3.1.4. Дүрслэх урлагийн шилдэг бүтээл (Дүрслэх урлаг)

Соёлын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.7-д заасан үйл ажиллагаа эрхэлдэг иргэн, хуулийн этгээдийн бүтээлч үйл ажиллагааны үр дүнд бий болсон, нийгмийн эрэлт хэрэгцээнд нийцсэн, үндэсний өв уламжлал, ёс заншил, соёлын онцлогийг агуулсан, дэвшилтэт технологи, инновацад суурилсан, импортыг орлох, олон улсад өрсөлдөх чадвартай дүрслэх урлагийн бүтээлд (*уран зураг, баримал, зураасан зураг, чимэглэх урлаг, уран сайхны гэрэл зураг, гар урлал гэх мэт*) олгох шагнал

3.1.5. Кино урлагийн шилдэг бүтээл (Кино, дуу, дүрс)

Соёлын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.8-д заасан үйл ажиллагаа эрхэлдэг иргэн, хуулийн этгээдийн бүтээлч үйл ажиллагааны үр дүнд бий болсон, нийгмийн эрэлт хэрэгцээнд нийцсэн, үндэсний өв уламжлал, ёс заншил, соёлын онцлогийг агуулсан, дэвшилтэт технологи, инновацад суурилсан, импортыг орлох, экспортод чиглэсэн, өрсөлдөх чадвартай кино урлагийн бүтээлд (*уран сайхны, түүхэн, баримтат, хүүхэлдэйн, анимешн гэх мэт*) олгох шагнал

3.1.6. Шилдэг уран сайхны нийтлэл, нэвтрүүлэг (Хэвлэл мэдээлэл)

Соёлын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.8-д заасан үйл ажиллагаа эрхэлдэг иргэн, хуулийн этгээдийн бүтээлч үйл ажиллагааны үр дүнд бий болсон нийгмийн эрэлт хэрэгцээнд нийцсэн, үндэсний өв уламжлал, ёс заншил, соёлын онцлогийг агуулсан, дэвшилтэт технологи, инновацад суурилсан, уран сайхны нийтлэл (*түүх, соёл, ёс заншил, хэл зохиол, зан үйл, өв соёлыг тайлбарлан таниулсан*) уран сайхны нэвтрүүлэг (*хөрөг, тэмцээн уралдаан, тв шоу, реалити шоу, урлаг уран сайхны үзүүлбэр, теле зохиомж гэх мэт*) бүтээлд олгох шагнал

3.1.7. Шилдэг цахим бүтээл (Дижитал инноваци, контент)

Соёлын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.9-д заасан үйл ажиллагаа эрхэлдэг иргэн, хуулийн этгээдийн бүтээн туурвисан, нийгмийн эрэлт хэрэгцээнд нийцсэн, үндэсний өв уламжлал, ёс заншил, соёлын онцлогийг агуулсан импортыг орлох, экспортод чиглэсэн, өрсөлдөх чадвартай, интернэт орчин, тоон технологид суурилсан, шинжлэх ухаан, харилцаа холбоо, урлагийн виртуал объектын цахим хуулбар бүтээлд (*программ хангамж, цахим тоглоом гэх мэт*) олгох шагнал

3.1.8. Архитектурын шилдэг бүтээл (Уран барилга)

Соёлын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.10-д заасан архитектур, уран барилгын чиглэлээр үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэгч иргэн, хуулийн этгээдийн бүтээлч үйл ажиллагааны үр дүнд бий болсон, орон зайн болон гоо зүйн хувьд нийгмийн эрэлт хэрэгцээнд нийцсэн уран барилгад (*шилдэг шийдлүүд, тэргүүний технологи Ноу-Хау нутагшуулан хэрэгжүүлсэн*) олгох шагнал

3.1.9. “Дизайны шилдэг бүтээл (Дизайн)

Соёлын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.10-д заасан дизайны чиглэлээр

үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэгч иргэн, хуулийн этгээдийн бүтээлч үйл ажиллагааны үр дүнд бий болсон, нийгмийн эрэлт хэрэгцээнд нийцсэн, үндэсний өв уламжлал, ёс заншил, соёлын онцлогийг агуулсан, дэвшилтэт технологи, инновацад суурилсан үйлдвэрлэлийн дизайны бүтээлд (*дизайн, интерьер, экстерьерийн болон зураг төслийн шилдэг шийдлүүд, технологи Ноу-Хауг нутагшуулан хэрэгжүүлсэн*) олгох шагнал

3.1.10. Шилдэг хувцас загвар (Хувцас загвар)

Соёлын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.10-д заасан дизайн, хувцас загварын чиглэлээр үйлдвэрлэл, үйлчилгээ эрхэлдэг иргэн, хуулийн этгээдийн бүтээлч үйл ажиллагааны үр дүнд бий болсон үндэсний өв уламжлал, ёс заншил, соёлын онцлогийг агуулсан, дэвшилтэт технологи, инновацад суурилсан, импортыг орлох, экспортод чиглэсэн, өрсөлдөх чадвартай, үйлдвэрлэлийн аргаар хийх боломжтой хэлбэр, хийцэд хамаарах өвөрмөц, шинэ шийдэл бүхий хувцас үйлдвэрлэлийн бүтээгдэхүүний загварт олгох шагнал

3.1.12 Зар сурталчилгааны шилдэг бүтээл (*Маркетинг, брэндинг, коммуникаци*)

Иргэн, хуулийн этгээдээс бараа, ажил, үйлчилгээ, бүтээгдэхүүний зах зээлийн эрэлтийг нэмэгдүүлэх, боломжит хэрэглэгчийн анхаарлыг татах зорилгоор олон нийтийн хэвлэл мэдээллийн хэрэгсэл болон бусад хэлбэрээр түгээсэн, нийгмийн эрэлт хэрэгцээнд нийцсэн, үндэсний өв уламжлал, ёс заншил, соёлын онцлогийг агуулсан, дэвшилтэт технологи, инновацад суурилсан, өрсөлдөх чадвартай уран сайхан, танин мэдэхүйн ач холбогдолтой зар сурталчилгааны бүтээлд олгох шагнал

ДӨРӨВ. ШАЛГАРУУЛАЛТАД ИРҮҮЛЭХ МАТЕРИАЛЫН БҮРДҮҮЛЭЛТ

4.1. Бүтээл туурвисан уран бүтээлч, эрх эзэмшигч нь шилдэг бүтээл шалгаруулах номинацид сүүлийн 2 жилийн хугацаанд бүтээн туурвисан бүтээлийг нэр дэвшүүлнэ.

4.2 Шалгаруулалтад ирүүлэх материал

4.2.1 Бүтээл, түүний товч танилцуулга, тодорхойлолт

4.2.2 Зохиогчийн танилцуулга, уран бүтээлийн жагсаалт

4.2.3 Бүтээлийн талаар 2 - оос доошгүй эрдэмтэн, судлаачдын дүгнэлт, шүүмж

4.2.4 Бүтээлийн зохиогчийн эрхийн зөрчилгүйг нотлох баримт

4.2.5 Бүтээлийн зураг болон pdf, аудио, видео файл зэрэг холбогдох мэдээлэл

4.3 Тухайн бүтээлийг хэвлэн нийтлүүлсэн, үйлдвэрлэлд нэвтрүүлсэн, нийтэд түгээсэн аж ахуйн нэгж, байгууллагын дүгнэлт, гарсан үр дүнгийн талаарх мэдээлэл болон бүтээлийг экспортлосон эсхүл импорт орлох бүтээгдэхүүнийг нотлох баримтыг ирүүлвэл давуу тал болно.

ТАВ. НЭР ДЭВШИЖ БУЙ БҮТЭЭЛИЙГ ХҮЛЭЭН АВАХ

5.1. Шалгаруулалтад нэр дэвшүүлж буй бүтээл нь тавигдах шаардлага, зохих бүрдүүлэлтийг хангасан байх ба бүрдүүлсэн материал, баримт бичгийн хамт зохиогч эсвэл түүний итгэмжлэгдсэн төлөөлөгч нь Соёлын яамны **moc.gov.mn** вэб сайтад байрлах линкээр бүртгүүлнэ. Холбоо барих утас: 51-265628

5.2 Бүртгэлийн хугацаа 2022 оны 12 дугаар сарын 30- ны өдрийн 09.00 цагаас 01 дүгээр сарын 14 ны өдрийн 18.00 цаг хүртэлх хугацаанд үргэлжилнэ.

5.3. Нэр дэвшүүлэхээр ирүүлсэн бүтээлийн материалыг нэр дэвшүүлэгчид буцаан олгохгүй.

5.4. Зохион байгуулагчаас тухай бүтээл шалгарсан эсэхийг буцааж мэдэгдэх үүрэг хүлээхгүй.

5.5. Нэр дэвшүүлэхээр ирүүлсэн материалыг дараах тохиолдолд шалгаруулалтад оролцуулах боломжгүйд тооцно.

- 5.5.1. Материалын бүрдүүлбэр заагдсан шаардлага хангаагүй, дутуу бүрдүүлсэн;
- 5.5.2 Материалын бүрдүүлбэрийг хуурамчаар бүрдүүлсэн;
- 5.5.3 Хүсэлтийг журамд заасан хугацаанд ирүүлээгүй.

5.6. Шаардлага хангасан бүтээл нэр дэвшээгүй тохиолдолд тухайн төрлийн шагналыг олгохгүй байж болно.

ЗУРГАА. ШИЛДЭГ БҮТЭЭЛИЙГ ШАЛГАРУУЛАХ, ШАГНАХ

6.1. Нэр дэвшсэн бүтээлийг сонгон шалгаруулах ажлын хэсэг байгуулагдаж ажиллана.

6.2. “Оны шилдэг бүтээл” шалгаруулах ажлын хэсэг хуралдааны хэлбэрээр ажиллана. Нийт гишүүдийн 80 хувь оролцсон тохиолдолд хуралдааныг хүчинтэйд тооцно.

6.3. Ажлын хэсгийн гишүүд шалгуур үзүүлэлтэд нийцүүлэн тухайн бүтээл тус бүр 1-10 хүртэлх үнэлгээг нууцаар өгнө. / Хавсралт маягт-1 /

6.4. Ажлын хэсгийн гишүүдийн өгсөн оноог нэгтгэн дүгнэж, Хавсралт 2 - д дурдсан маягтын дагуу онооны нийлбэрээр тухайн бүтээлийн эцсийн үнэлгээг гаргана.

6.5 Сонгон шалгаруулах ажлын хэсгийн дүнг үндэслэн “Оны шилдэг бүтээл” - ийн шагналыг олгоно.

6.6. “Оны шилдэг бүтээл”- ийн шагнал, дагалдах батламж, урамшууллыг гардуулах ёслолын ажиллагааг хүндэтгэлтэйгээр зохион байгуулна.

ОНЫ ШИЛДЭГ БҮТЭЭЛД ДЭВШСЭН БҮТЭЭЛИЙН ҮНЭЛГЭЭНИЙ ХҮСНЭГТ

№	Бүтээлийн нэр	Дүгнэх шалгуур үзүүлэлт						Нийт оноо
		Үндэсний соёлын онцлогийг агуулсан байдал	Нийгэмд үзүүлж буй эерэг нөлөөлөл	Эдийн засгийн үр өгөөж	Импортыг орлох, экспортод чиглэсэн өрсөлдөх чадвар	Дэвшилтэт технологи, инновац, шинэлэг байдал	Эрхийн хамгаалалт хийгдсэн эсэх	
1								
2								
3								

Үнэлгээ өгсөн: /

/Гарын үсэг

... он ... сар ... өдөр

МАЯГТ 2

ОНЫ ШИЛДЭГ БҮТЭЭЛД ДЭВШСЭН БҮТЭЭЛИЙН ҮНЭЛГЭЭНИЙ НЭГДСЭН ДҮНГИЙН ХҮСНЭГТ

[illegible][illegible]